



Элчин сайдын 2018 оны 10 дугаар сарын  
өдрийн 05/ тоот тушаалын хавсралт № 1

**БАТЛАВ:**

**МОНГОЛ УЛСААС ОХУ-Д СУУГАА ОНЦ  
БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД**

**Б.ДЭЛГЭРМАА**

2018 оны 10 дугаар сарын "02"-ны өдөр

**МОНГОЛ-ОРОСЫН 59 ДЭХ УДААГИЙН НАЙРАМДЛЫН  
САРЫН ХҮРЭЭНД ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД СУРАЛЦАЖ БУЙ  
МОНГОЛ ОЮУТНУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
СПОРТЫН НААДМЫН УДИРДАМЖ**  
*/Оросын Холбооны Улс, Москва хот,  
2018 оны 10 дугаар сарын 13-14/*

### НЭГ. ЗОРИЛГО

Оюутны дунд спортыг хөгжүүлэх, оюутан залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэх сонирхлыг идэвхжүүлэх үндсэн зорилготой.

### ХОЁР. СПОРТЫН ТӨРӨЛ, ХУГАЦАА

Наадмыг спортын Сагсан бөмбөгийн төрлөөр **2018 оны 10 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо** зохион байгуулна.

Тэмцээн 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 09.00 цагт Оросын ард түмний найрамдлын их сургуулийн спортын танхимд эхэлнэ.

### ГУРАВ. БАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН ЖУРАМ

Наадамд зөвхөн ОХУ-ын их дээд сургуульд суралцаж буй Монгол Улсын оюутан, залуучууд хамрагдах бөгөөд насны хязгаар заахгүй. Тэмцээнд оролцогчид нь суралцаж буй сургуулиа төлөөлсөн хэлбэрээр оролцож болно. Баг бүрдүүлэхэд тамирчид хурэлцэхгүй тохиолдолд 2-оос дээшгүй сургуулийн тамирчид нэгдэн оролцохыг зөвшөөрнө.

Наадмыг зохион байгуулж буй ЭСЯ-ны зохион байгуулах хороо нь тухайн тэмцээн явуулж байх үедээ ОРОЛЦОГЧДЫН эрүүл-мэнд, аюулгүй байдал, спорт заалны хэвийн ажиллагаа, тамирчид, үзэгчдийн хэв журам зөрчил, спортын бус зан авир гаргуулахгүй байх, шүүлтийн зөрчил гаргахгүй зэрэг зохион байгуулалтын бүх талын арга хэмжээг авна. Багууд харилцан бие биенээ хүндэтгэж, шударга өрсөлдөнө. Харилцааны болоод, ёс зүйн зөрчил гаргасан, согтууруулах ундаа хэрэглэсэн тамирчдыг тэмцээний дүрмийн дагуу тэмцээнээс хасах арга хэмжээг авна.

Тэмцээнд оролцох их, дээд сургуулийн багууд нь өөрсдийн сургуулийн онцлогийг илэрхийлсэн нэгдсэн бэлтгэлийн хувцас, өмсгөлтэй байна.

### ДӨРӨВ. МЭДҮҮЛГИЙН ЖУРАМ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

Тэмцээнд оролцох баг, тамирчдын бүртгэл **2018 оны 10 дугаар сарын 12-ний дотор явагдаж дуусна.** /Хавсралт - мэдүүлгийн маягт/ Тэмцээнд оролцох урьдчилсан мэдүүлгийг [smunkhuu7@gmail.com](mailto:smunkhuu7@gmail.com) цахим хаяг руу ирүүлж,

бүртгүүлэх боломжтой. Албан ёсны мэдүүлэггүй, мэдүүлгийн хугацаа хожимдуулсан, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу нөхцөлд бүртгэлд хамруулахгүй. Бүртгэлийг 2018 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн 16.00 цагт Элчин сайдын яамны Консулын хэлтсийн байранд /хаяг: Спасопесковский переулок, дом 7/1/ хийнэ. Тамирчид урьдчилан ирүүлсэн багийн мэдүүлгийн дагуу өөрийн биеэр ирж паспорт болон оюутны үнэмлэхээ үзүүлэн мандатаа авна.

**Тэмцээний техникийн зөвлөгөөнийг мандат олгосны дараа хийнэ.**

#### **ТАВ. ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

##### **1. Сагсан бөмбөг**

Тэмцээнд их, дээд сургуулийн эрэгтэй, эмэгтэй тус бүр нэг баг оролцоно. Баг нь эрэгтэй 8, эмэгтэй 8 тамирчны бүрэлдэхүүнтэй байна. Тэмцээний тоглолтууд 2 үеэр зохиогдох бөгөөд үе тус бүр 8 минутаар үргэлжилнэ. Тамирчдын хувцаслалт нь нэгдсэн загвартай, ижил өнгийн байна. Тоглолтын хуваарийг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.

Тэмцээнд амжилттай оролцож байр эзэлсэн сургуулийн баг, тамирчдыг өргөмжлөл, медаль, мөнгөн урамшууллаар шагнана.

#### **ЗУРГАА. ДҮГНЭХ ЖУРАМ**

Тэмцээний дүнг спортын төрөл тус бүрт оролцогч тус бүрийг дүгнэн алт, мөнгө, хүрэл медалийн эздийг тодруулна. Спортын төрлийн шүүгчдийн зөвлөл нь тухайн спортын төрлийн тэмцээнийг явуулахдаа тамирчдыг дараалан байр эзлүүлэх журмаар тэмцээнийг удирдан явуулна.

#### **ДОЛОО. БУСАД**

Тэмцээнд оролцохоор ирж буй оюутан залуус байр, хоол, унааны зардлаа өөрсдөө хариуцна.

